

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 03 дугаар сарын 20-ний өдөр

ТУЗТ 06/2022

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурал зарлан хуралдуулах
тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дүгээр хэсэг, 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.6 дэх хэсгүүд, 71 дүгээр зүйлийн 71.3, 71.4 дэх хэсгүүд, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дэх хэсгүүд, “Эрдэнэс сольюшинс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дэх хэсгүүд, 9 дүгээр зүйлийн 9.10.10, 9.10.11 дэх хэсгүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 12.00 цагт Google Meet joining info; Video call link: <https://meet.google.com/mmi-dmwe-pnc> програмыг ашиглан, иргэний үнэмлэх, итгэмжлэлийг өөрийн зурагтай зэрэг камерт тулган баталгаажуулах байдлаар зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах этгээдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т. Золбоог томилсугай.
3. Энэ тогтоолын 1-т заасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг 1 дүгээр хавсралтаар, хурлын хөтөлбөр, дэгийг 2 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын танилцаж болох баримт материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загварыг 4 дүгээр хавсралтаар, тооллогын комиссын тогтоолын төслүүдийг 5, 6-р хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлийг 7-р хавсралтаар тус тус баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 10-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар, мэдээг 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрөөр дахин зарлах өдрийг 15 өдрийн дараа байхаар тогтоож, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсны дагуу “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журамд заасан хэлбэр, шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /П.Ням-Очир /-д даалгасугай.
6. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 17.00 цаг хүртэл ажлын өдрүүдэд ажлын 9-17 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, 40 50 мянгат, Бакула ринбучийн гудамж, 30-р байр,

10-р давхарт “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн байранд танилцуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс / П.Ням-Очир /-д даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокерын компаниар дамжуулан авч байгаа тохиолдолд уг саналын хуудсыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 16 цагаас өмнө байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
9. Хурал зохион байгуулах комиссын даргаар П.Ням-Очир, гишүүнээр Г. Төгөлдөр нарыг, Тооллогын комиссын даргаар Г. Төгөлдөр, гишүүнээр: П.Ням-Очир нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Л.ЗОЛБОО/

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТУЗТ 06/2022 тоот тогтоолын 1 дүгээр хавералт



**“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ЖАГСААЛТ**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Компанийн хаяг дүрэмд тусгах тухай;

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТУЗТ 06/2022 тоот тогтоолын 2 дугаар хавсралт



“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИГ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ

№	Хэлэлцэх асуудал	Шийдвэрийн төсөл	Эхлэх, дуусах хугацаа/цагаар/	Хариуцах эзэн
1.	Хуралд оролцогчдыг бүртгэх		12.00-12.10	Хурал зохион байгуулах комисс
2.	Хурлын ирцийн дүн гаргах, танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	12.10-12.25	Тооллогын комисс
3.	Хурлыг нээж, хурлын дарга үг хэлнэ.		12.25-12.30	Хурлын дарга
4.	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	12.30-12.40	ТУЗ-ын дарга
5.	Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний эцсийн байдлаар санхүүгийн дүгнэлт хэлэлцэж батлах тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	12.40-12.50	ТУЗ-ын дарга
6.	Компанийн хаяг дүрэмд тусгах тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	12.50-12.55	ТУЗ-ын дарга
7.	Асуулт, хариулт		12.55-13.30	Хурлын дарга
8.	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал асуултын хуудсаар санал хураах;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	13.00-14.00	Тооллогын комисс
9.	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүд гарах;	Тооллогын комиссын тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	14.00-14.30	Тооллогын комисс
10.	Хурлыг хаах		14.30-14.40	Хурлын дарга

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТУЗТ 06/2022 тоот тогтоолын 3 дугаар кавсралт



**“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай хурлын тэмдэглэл, шийдвэр;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан;
3. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн дүгнэлт;

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТУЗТ 06/2022 тоот тогтоолын 4 дүгээр хавсралт



Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загвар

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал 2022 оны 04-р сарын 30-ний өдрийн 12.00 цагт Google Meet joining info; Video call link: <https://meet.google.com/mmi-dmwe-rnc> програмыг ашиглан, иргэний үнэмлэх, итгэмжлэлийг өөрийн биеийг давхар камерт тулган баталгаажуулан харуулах байдлаар зарлан хуралдуулсугай.

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр: 2022-04-10

Хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Компанийн хаяг дүрэмд тусгах тухай;

Хурлын материалтай 2022 оны 03-р сарын 22-ний өдрөөс 2022 оны 04-р сарын 29-ны хооронд ажлын өдрүүдэд 9-17 цагийн хооронд УБ, ЧД, 40-50 мянгат, Бакула ренбүчийн гудамж, 30-р байр, 10-р давхар, Эрдэнэс сольюшинс ХК-ийн байранд ирж танилцах боломжтой.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс П. Ням-Очир, Г.Төгөлдөр

Утас: 99037119

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“Эрдэнэ сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн ТУЗТ 06/2021 тоот тогтоолын 5 дугаар хэсэгт



“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр

№ ТК 01/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын ирцийн бүртгэлийн
тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8 дахь заалтууд, 69 дугаар зүйлийн 69.1 дэх хэсэг, “Эрдэнэ сольюшинс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн ээлжит хурлын ирц (кворум)-ийн бүртгэлийг үндэслээд **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Компанийн саналын эрх бүхий хувьцааны /...../ хувь буюу /...../ ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн саналын эрх бүхий хувьцааны /...../ хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байх тул Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН
ДАРГА

/Г.ТӨГӨЛДӨР/



“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр № ТК 02/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

Компанийн ээлжит хуралд
оролцогсдын саналын хуудас
тоолсон тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2, 67.3.8 дахь заалтууд, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.2 дэх хэсгүүд, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэг, “Эрдэнэ сольюшинс” ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн ээлжит хуралд оролцсон саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. Компанийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид тус хурлаар хэлэлцэж буй асуудал тус бүрээр Google Meet joining info; Video call link: <https://meet.google.com/mmi-dmwe-pnc> програмыг ашиглан санал өгснийг дараах байдлаар нэгтгэв. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн								Нийт	
		Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Хүчингүй болсон			
		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай										
2	Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай										
3	Компанийн оршин байгаа газар, хаягийг солих тухай										

2. Энэхүү тооллогын комиссын тогтоолын 1-д заасан нэгтгэлийг хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 30-ний өдрийн ээлжит хуралд танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН

ДАРГА

/ Г.ТӨГӨЛДӨР /

ГИШҮҮН

/ П.НЯМ-ОЧИР /

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТУЗТ 06/2022 тоот тогтоолын 7 дугаар хавсралт ТӨСӨЛ



“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр

№ ХЭХ 01/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан баталж, компанийн хаягийн өөрчлөлтийг бүртгэх тухай

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9, 62.1.15 дэх хэсгүүд, 63 дугаар зүйл, 69 дүгээр зүйл, “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дах заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТУЗТ 06/2022 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар аудит хийгдсэн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн оршин байгаа газар, хаягийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40 50 мянгат, Бакула ринбучийн гудамж, 30-р байр, 10-р давхар гэж өөрчилсүгэй.
4. Компанийн хаяг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Компанийн дүрмийг 1-р хавсралтаар баталсугай.
5. Компанийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн ээлжит хурлын 12.00 цагт Google Meet joining info; Video call link: <https://meet.google.com/mmi-dmwe-pnc> байхаар зарлан хуралдуулсан видео бичлэгийг хадгалсугай.

ХУРЛЫН ДАРГА

/ Т. ЗОЛБОО /